



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/05

Мандалговь

Төсвийн сар, улирлын хуваарь  
батлах тухай

Монгол Улсын 2020 оны төсвийн сар, улирлын хуваарь батлагдсантай холбогдуулан, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.а дахь заалт, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн төсвийн хуваарийг нэгдүгээр, Аймгийн засаг даргын Тамгын газрын төсвийн хуваарийг хоёрдугаар, Сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төсвийн хуваарийг гуравдугаар, Сумдын Засаг даргын Тамгын газрын төсвийн хуваарийг дөрөвдүгээр, Ерөнхий боловсролын байгууллагуудын төсвийн хуваарийг тавдугаар Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын төсвийн хуваарийг зургадугаар, Соёлын байгууллагуудын төсвийн хуваарийг долдугаар, Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний байгууллагуудын төсвийн хуваарийг наймдугаар, Төсөвтэй шууд харьцдаг байгууллагуудын төсвийн хуваарийг есдүгээр хавсралтаар тус тус баталсугай

Хоёр. Батлагдсан хуваарийн дагуу тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын санхүүжилтийг олгож, хэрэгжилтийг хянаж, төсвийн гүйцэтгэлийг сар бүр үнэн зөв мэдээлж, төсвийн ил тод байдлыг хангаж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (А.Ганбат)-т үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010012